



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/824

Хэрлэн сум

Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн
гэрээний биелэлтийг үнэлэх ажлын хэсэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 29.1.5-ын "а, г", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/05 дугаар тушаалыг үндэслэн өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн анхан шатны тусламж үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хагас бүтэн жилээр үнэлж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2014 оны А/39 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

05 Аймгийн Засаг даргын 2019 оны
дугаар сарын 07 өдрийн А/224
дугаар захирамжийн хавсралт



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭГ
ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн
дарга

ЭМГ-ын Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Эх, нярайн тусламж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Хүүхдийн тусламж үйлчилгээ, хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭМГ-ын Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн
холбооны төлөөлөл

Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга